




БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Төлөвлөгөөний биелэлтийг хянасан:

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА



Төсвийн Төвлөрүүлэн захирагч

/ Э.БАТТУЛГА /

(ОГНОО)

Төлөвлөгөөг тайлганасан:

БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Төсвийн Шууд захирагч

/ Б.НАНДИНБАТ /

(ОГНОО)

**БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
-----	---	-------	------------------	--------------	-----------------	---	----------------

1	2	3	4	5	6	7	8
---	---	---	---	---	---	---	---

**НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Агаарын тухай хуулийн 7.1.2, 27.1, 27.2 заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А479 тушаал “Журам батлах тухай”, 2014/А-181: “Агаар бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”, “Агаар бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах заавар, Үндсэн чиглэлийн 2021-2025 3.2.1

1.1	Агаарын бохирдлын эх үүсвэрийн Улсын нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах, мэдээ тайланг хүлээн авч нэгтгэн боловсруулах, БОУАӨЯ, Аймгийн ЗДТГ-т тайлагнах	Улсын төсөв	Сумдын агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэлийн тоо	АБЭҮ-ийн тооллогын ажил 16 сумыг хамруулан явуулсан. <b>Гүйцэтгэл 100%</b>	Тооллогын үр дүнг хүлээн авч тайланг хугацаанд нь 100 хувь хийж гүйцэтгэнэ	2024 онд Булган аймгийн 16 сум, 1 тосгоны нийт 7367 айл өрхийн түлш хэрэглээний мэдээллийг бүртгэлжүүлж мэдээллийн санд оруулсан. Аймгийн хэмжээнд нийт 15,894 утаа гаргадаг айл өрх байгаагаас 4,617 тн нүүрс, 75,901 м³ мод болон 16,439 тн бусад төрлийн түлш хэрэглэсэн байна. Агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн хүрээнд уурын болон усан халаалтын нийт 54 зуухыг бүртгэн, хэрэглэсэн түлшний мэдээллийг шинэчиллээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• 15–100 кВт хүчин чадалтай 21 зуух - 1,052 тн нүүрс, 840 м³ мод,</li> <li>• 100–4,200 кВт хүчин чадалтай 31 зуух - 16,565 тн нүүрс,</li> <li>• 4,200 кВт-аас дээш хүчин чадалтай 2 зуух - 21,366 тн нүүрс хэрэглэсэн байна.</li> </ul> Мөн 2024 оны агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрийн бүртгэлийн дагуу аймгийн хэмжээнд бүртгэлтэй 13,799 авто тээврийн хэрэгсэл байгаагаас 13,109 нь үзлэг оношлогоонд хамрагдсан байна.	100
-----	---	-------------	---	---	--	---	-----

1	2	3	4	5	6	7	8
1.2	Гурванбулаг, Хутаг өртөөний автомат станцыг шинэчлэх, суурилуулах;	Улсын төсөв	Ажлын үзүүлэлт, хувиар	2024 онд 2 автомат станц хуваарилагдсан	Хуваарилагдсан 2 автомат станцыг суурилуулж ашиглалтанд оруулсан байна	Гурванбулаг, Хутаг өртөөнд Финлянд улсад үйлдвэрлэсэн AWS-310B маркийн Цаг уурын ажиглалтын автомат төхөөрөмжийг технологийн дагуу суурилуулав. Төхөөрөмжийн иж бүрдэлд: QML201 Дата логгер 1ш, мемори карт 2ш WAV151 WD SN:W3252621 дугаартай салхины зүг мэдрүүр-1ш, WAA151 SN:W3714556 дугаартай анемометр-1ш WAC155 AWS SN:W3852564 дугаартай салхины хурдны мэдрүүр 1ш, HMP155E1 SN:W3843667 дугаартай чийг температурын мэдрүүр 1ш, BARO-1QML-AH SN:V3940045 дугаартай даралтын мэдрүүр 1ш Батерей SN:23092625275355 дугаартай 12V,24AH 1ш PT100 хөрсний мэдрүүр 1ш суурилуулж ашиглалтанд хүлээлгэн өгөв. Мөн 5 сард Хутаг өртөөний автомат станцын хурын хувинг суурилуулж, ADAM-4520 загварын RS485 конвертер нэмж тавив. Шинээр тавигдсан AWS-310B маркийн автомат станцуудын тоног төхөөрөмжийн техникийн паспорт нээж бүртгэл тэмдэглэл хийн ажиллаж байна.	100
1.3	Ингэттолгой өртөөний барилгын гадна дулаан, цэвэр усны шугамыг холбох	Улсын төсөв	Цэвэр, бохир усны шугманд холбогдсон өртөөний тоо	-	1	Тус өртөөний барилгын гадна дулаан болон цэвэр усны шугамын холболтын зардлыг шийдвэрлүүлэх зорилгоор аймаг, орон нутгийн түвшинд ИТХ, АЗДТГ болон Сэлэнгэ сумын төлөөлөгч Насандулам, Юмжирмаа нарт удаа дараа албан бичиг хүргүүлж ажиллав. Уг ажлын үр дүнд холбогдох зардлыг 2026 оны төсөвт тусгуулахаар шийдвэрлүүлсэн.	80

1	2	3	4	5	6	7	8
1.4	Ус судлалын Сэлэнгэ-Хутаг, Сэлэнгэ-Хялганат харуулд мэдээлэл нь нээлттэй харагддаг усны түвшин хэмжих автомат багаж суурилуулах;	Улсын төсөв	Автомат түвшин хэмжигч багаж суурилуулсан харуулын тоо;	0	2	ЦУОШГ-аас 1 автомат багаж хуваарилсан. Уг автомат багажийн суурилуулах санхүүжилтийг Аймгийн ЗДТГ-т хүсэлт хүргүүлснээр 11 сарын эхээр шийдэгдсэн боловч цаг агаар хүйтэрч, гүүрний бетон байгууламж дээр бетон цавуу наалдахгүй, багаж суурилуулах технологийн горим хангагдахгүй, улмаар багаж гэмтэх эрсдэлтэй байгаа тул уг ажлыг 2026 оны хавар дулаан ороход гүйцэтгэхээр болсон.	85
1.5	Салбаруудыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах технологийн хяналт тавих	Улсын төсөв	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын ажлын дүн	Шалган туслах ажлын төлөвлөгөө - 85%	90% хүргэнэ	Бүх салбарыг арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Технологийн хяналт шалгалтыг Сэлэнгэ, Хутаг, Сайхан, Бүрэгхангай, Орхон, Ачуут-Булган, Зүүнтүрүү-Булган, Орхон-Орхон, Хануй-Баян-Агт, Орхон-Сайхан ус судлалын харуул, МААЦУ-ын хонины харуулд хийсэн байна. Тухайн салбаруудад ажиглалтын технологи баримтлалт, үүлний ажиглалтын технологи мөрдөлтөнд хяналт тавьж, өртөө, харуулын дотоод ажил шалгасан. Үзэгдлийн эрчимшилд анхаарах, эхэлсэн дууссан хугацааг нарийвчилж авах зөв ажиглах талаар зааварчилгаа өгч салбаруудын ажиглагч, техникч нараас мэргэжлийн чиглэлээр түвшин тогтоох шалгалт авч ажилласан.  2025.05.09-нд МААЦУ-н хонь, ямааны харуулд очиж Дархан-Уул аймгийн ХААИС-ийн Цаг уур судлалын мэргэжлийн 2, 3-р дамжааны оюутнуудад МААЦУ-н харуулын үйл ажиллагааг танилцуулж, практик дадлага хийлгэв.	80

1	2	3	4	5	6	7	8
						Төсөв хөрөнгө дутагдалтай шалган туслах ажил бүрэн хийгдээгүй байна.	
1.6	Байгаль орчны шинжилгээний лабораторийг давтан итгэмжлэлд хамруулна	Улсын төсөв	Итгэмжлэлийн гэрээ, гэрчилгээ тоо	2024 онд нийт 18 иргэн, ААН-үүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан орчны хяналт шинжилгээний ажил хийж нийт 9,3 сая төгрөгний орлого төвлөрүүлсэн <b>Гүйцэтгэл 100%</b>	БОШЛ-ийн үйл ажиллагааг өргөтгөнө <b>Гүйцэтгэл 100% байна.</b>	Үндэсний итгэмжлэлийн төвөөс тавигдаж буй санамж бичгийн хүрээнд БОХЗТЛ-ийн харъяа 21 салбар БОШЛ-ийг нэгдсэн байдлаар итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажил хийгдэж байна. Давтан итгэмжлэлд хамрагдах өргөдөлөө нэгдсэн журмаар өгсөн	80
1.7	Агаарын бохирдлыг хянах байнгийн ажиллагаатай автомат станцыг БНСУ-ын хөрөнгө оруулалтаар суурилуулах	БНСУ-ын хөрөнгө р	Агаарын бохирдлыг олон үзүүлэлтээр хянах автомат станцын тоо	-	1	2025 оны 06 дугаар сарын 27-ноос 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Агаарын чанарын автомат станцыг суурилуулж, станц хэвийн горимоор ажиллаж эхэллээ. Одоогоор станцын ажиллагаатай холбоотой боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх сургалтууд шат дараатай зохион байгуулагдаж байна.	100
1.8	Аймгийн хэмжээнд Уур амьсгалын ангилал боловсруулж гаргах	Улсын төсөв	Уур амьсгалын ангилал мэдээлэл гаргасан цаг уурын үзүүлэлтийн тоо	-	1	Хамгийн хүйтэн сарын дундаж температур, хамгийн дулаан сарын дундаж температур, жилийн дундаж температур, жилийн дундаж нийлбэр хур тунадас, IV-IX саруудаас хур тунадас бага ордог сарын нийлбэр хур тунадас, IV-IX саруудаас хур тунадас хамгийн их ордог сарын нийлбэр хур тунадас, X-III саруудаас хур тунадас бага ордог сарын нийлбэр хур тунадас, X-III саруудаас хур тунадас хамгийн их ордог сарын	100

1	2	3	4	5	6	7	8
						нийлбэр хур тунадас зэрэг 8 үзүүлэлтээр уур амьсгалын ангиллыг 1 дүгээр сарын 01-нээс 31-ний хооронд хийж дүгнэлтийг гарган мэргэжилтэн Амгаланд хүргүүлсэн.	
<b>ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, ЗГ-н 286-р тогтоол, Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А/02 тоот тушаал							
Ус цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам, Хэмжил зүйн тухай хууль							
2.1	Цаг уурын 6 өртөө, 10 харуул, ус судлалын харуулуудын мэдээг олон улсын болон бүсийн солилцоонд хяналтын хугацаанд бүрэн дамжуулах, байгууллагын сүлжээ ашиглалтын хэвийн ажиллагаа аюулгүй байдлыг хангах	Улсын төсөв	Сүлжээ ашиглалт, мэдээ дамжуулалтын дүн, %	2024 онд Сүлжээ ашиглалт, мэдээ дамжуулалтын дүн <b>99.99% ДҮГНЭГДСЭН</b>	99.99% хадгалана	Цаг уурын 6 өртөөний 17520, 10 харуулын 9834 мэдээг улс орон нутгийн мэдээлэл солилцоонд 100 % оруулсан, Сүлжээ ашиглалт, тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангагдан хэвийн ажиллаж байна.	100
2.2	Цаг уурын шинжилгээний өртөө, харуулуудад уур амьсгалын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай бүрэн хийж гүйцэтгэх	Улсын төсөв	-Хөтөлбөрт ажлын ерөнхий дүн хувь -Нэгдсэн дүн /хувиар/	2024 онд -Хөтөлбөрийн биелэлт 100%. Ажиглалтын чанар 99.0% Шүүмжийн чанар 99.4 % <b>-Нэгдсэн дүн 99.2% ДҮГНЭГДСЭН</b>	- Хөтөлбөрийн биелэлт 100%. Ажиглалтын чанар 99.1% Шүүмжийн чанар 99.7% <b>-Нэгдсэн дүн 99.4%-д хүргэнэ</b>	Тайлангийн хугацаанд ус цаг уурын өртөө, харуулууд хөтөлбөрт ажлыг бүрэн хийж төлөвлөгөөний биелэлт-100%, ажиглалтын чанар-98,9%, тайлангийн ирц-99,0%, мэдээний чанар 98,9% явцтай байна. Дундаж дүн 97.1%-тай ажиллаж өмнөх оны мөн үеэс 0.7%-н бууралттай ажилласан байна. Шүүмжийн чанар 99,7%тай байна. Өмнөх оноос 0.3% ахицтай байна.	100
2.3	Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалт болон хортон мэрэгчид, хөрсний гүний чийгийн ажиглалт хэмжилтийг хөтөлбөрийн хүрээнд бүрэн гүйцэтгэх,	Улсын төсөв	Хөтөлбөрт ажлын биелэлт /хувиар/ -Нэгдсэн дүн /хувиар/	2024 онд -Цаг уурын 16 салбарын Хөтөлбөрийн биелэлт 100%.	- Хөтөлбөрийн биелэлт 100%. Нэгдсэн дүн <b>100% хадгалана</b>	Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалт судалгааны ажлууд бүрэн хийгдсэн.х/б-100%, а/ч-97.85% байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.05%-аар өссөн 3-11-р сард Булган өртөөнд ЕМ-50 чийгийн автомат багажаар ажиглалт	100

1	2	3	4	5	6	7	8
				<b>Нэгдсэн дүн 100% дүгнэгдсэн</b>		<p>бүрэн хийгдсэн байна. Ингэттолгой өртөөнд 4-10-р сард хөрсний чийгшлийн ажиглалт бүрэн хийгдсэн. х/б-100%, а/ч-100% Хөрсний чийгийн явуул судалгааг 4 сард Бүрэгхангай, Хутаг, Тэшиг, Сэлэнгэ сумдад хийж Хаврын аялан судалгааны ажиглалт бүрэн хийгдэж төвд дамжуулсан. Өвлийн цасны явуул судалгааны ажиглалтыг 16 сумын 84 зогсоол цэгт 1 дүгээр сарын 3 дугаар 10 хоногт хийж, ХХ-2б хүснэгтийг санд шивж, цахим материалыг төвд хүргүүлэн ажиллаа.</p> <p>Бэлчээрийн хортон шавьж, мэрэгчдийн гаралт, тархалт өсөлт, хөнөөл учруулалтыг тооцох орчин зүйн ажиглалт бүрэн хийгдсэн. х/б-100%, а/ч-99.18 байгаа нь өмнөх оны дүнгээс 0.68%-аар ахисан. Мал аж ахуйн цаг уурын хонь, ямаа, үхрийн харуулд шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангаж цаг уурын болон малын аж ахуйн цаг уурын ажиглалт судалгаа бүрэн хийгдэж Хөтөлбөрийн биелэлт 100%, Ажиглалтын чанар 95.2% байгаа нь өмнөх оны дүнгээс 3.2%-аар өссөн үзүүлэлттэй байна. байна.</p>	
2.4	Аймгийн хэмжээнд өвлийн цасны болон зуны бэлчээрийн даац багтаамжийн явуул судалгааг зохион байгуулах, хөтөлбөрт ажлыг бүрэн гүйцэтгэх	Орон нутгийн төсөв	-16 сум, 83 багт судалгааг бүрэн хийсэн байна (тоо) Ажиглалтын чанар /хувиар/ Шүүмжийн чанар /хувиар/	2024 онд -Цаг уурын 16 салбарын Хөтөлбөрийн биелэлт 100%. Ажиглалтын чанар 100% Шүүмжийн чанар <b>100% дүгнэгдсэн</b>	Цаг уурын 16 салбарын Хөтөлбөрийн биелэлт 100%. Ажиглалтын чанар 100% Шүүмжийн чанар	Өвлийн цасны явуул судалгааны ажиглалтыг 16 сумын 84 зогсоол цэгт 1 дүгээр сарын 3 дугаар 10 хоногт хийж, ХХ-2б хүснэгтийг санд шивж, цахим материалыг төвд 100% хүргүүлэн ажиллаа. Зуны төлөв байдлын ажиглалт 16 сумын 83 багт судалгааг бүрэн хийгдсэн гүйцэтгэл 100%	100

1	2	3	4	5	6	7	8
					<b>100% хадгалана</b>		
2.5	Гадаргын ус судлалын шинжилгээний хөтөлбөрт ажлыг 12 салбар нэгжид бүрэн гүйцэтгэж ажилласан байх, урсац бодох	Улсын төсөв	-Төлөвлөгөөт ажлыг - (хувиар) Шинжилгээний ажлын чанар нэгдсэн дүнгээр (хувиар)	2024 онд -Төлөвлөгөөний биелэлт 99.6% Ажлын чанар - 97.1% Нэгдсэн дүн 98.3% дүгнэгдсэн	Төлөвлөгөөний биелэлт 99.8% Ажлын чанар - 97.2.% Нэгдсэн дүн 98.5.% хүргэнэ	Ус судлалын 12 харуулд шинжилгээний хөтөлбөрт ажлууд технологийн дагуу бүрэн хийгдэж ажиглалтын чанар 100%, а/ч 99,2%-тай, дундаж дүн 0,1%-иар өссөн байна. Түвшин 7330 удаа хэмжсэн. Харуулууд нийт 441 өнгөрөлт хэмжсэн байна.	100
2.6	Багаж, хэмжих хэрэгсэл, хэмжлийн төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалтыг төлөвлөгөөний дагуу бүрэн хийж ажилласан байх	Улсын төсөв	-Төлөвлөгдсөн хэмжих хэрэгслүүд шалгалт баталгаажуулалтанд бүрэн хамрагдсан тоо	2024 онд -Төлөвлөгөөний биелэлт 99% Ажлын чанар - 99% <b>Нэгдсэн дүн 99%</b>	Төлөвлөгөөний биелэлт 100 Ажлын чанар - 100% Нэгдсэн дүн <b>100%</b> хүргэнэ	БОХЗТЛ-т УЦУОШТ-ийн шалгалтын эталон багажууд болох цахилгаан барометр РТВ220 маркийн Х1950005 серийн дугаартай (агаарын даралтын) шалгалтын багаж НМР46 маркийн К0750008 серийн дугаартай (чийг температурын) шалгалтын багажуудыг тохируулга хийлгэн баталгаажуулалтад хамруулан гэрчилгээжүүлэх ажлыг 2025 оны 01 сард гүйцэтгэн РТВ220 багажид Г-2024/03 тоот, НМР46 багажид АӨ-2024/94 тоот баталгаажуулалтын гэрчилгээ авсан. БОХЗТЛабораториор баталгаажуулалт хийлгэж гэрчилгээг сунгуулав. Тус төвд одоо ашиглагдаж байгаа Цаг уурын автомат станцын Булган AWS-310, Могод AWS-330, Рашаант AWS-310, Бүрэгхангай, Баяннуур, Хишиг-Өндар CR-1000Х, Дашинчилэн зэрэг автомат станцуудыг мэдрүүрүүдийн заалтыг шалгалтын чийг температурын НМР46 болон агаарын даралтын РТВ220 багажтай харьцуулан шалгах ажлыг тус тус хийж үр дүнг өртөө тус бүрээр гарган материалыг нэгтгэн	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>БОХЗТЛ-т баталгаажуулалт хийлгэхээр хүргүүлэн ажиллаж гэрчилгээжүүлсэн. Байгаль орчин хэмжилзүйг төв лабораторт БАММ төрлийн 9634, 7838, 1264 серийн дугаартай Гурванбулаг, Могод, Ингэт өртөөний анериод баротетрийн багажийг баталгаажуулж баталгаажуулалтын гэрчилгээ авав. Булган Ингэттолгой, Хутаг өртөө, Бугат, Хангал харуул, Зоо цаг уурын хонь, ямааны харуулын Х-4500BF загварын 5000 г хэмжих хязгаартай электрон жингүүдийг Стандарт хэмжилзүйн газраар шалгалт тохируулгын ажлыг хийж баталгаажуулан баталгаажуулалтын гэрчилгээ авав. Булган өртөөний AWS-310 автомат станцын 139510, 139511 серийн дугаартай Пиранометр-СМРЗ багажуудыг БОХЗТЛабораториор баталгаажуулалт хийлгэж гэрчилгээг сунгуулав.</p>	
2.7	<p>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар хөрс гадаргын усны чанарын хяналт, орчны цацрагийн хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх</p>	Улсын төсөв	<p>-Хөтөлбөрт ажил бүрэн хангагдсан байна (хувиар) -шинжилгээний ажлын нэгдсэн дүн (хувиар)</p>	<p>2024 онд -Хөтөлбөрийн биелэлт 100% ажлын чанар нэгдсэн дүн <b>99,76 % дүгнэгдсэн</b></p>	<p>- Хөтөлбөрийн биелэлт 100 % - шинжилгээний ажлын чанар <b>99.78% хүргэнэ</b></p>	<p>Хөтөлбөрийн дагуу агаар, ус, хөрсний чанарын хяналтын дээжүүдийг 4, 5, 10 дугаар саруудад авч, төлөвлөгөөнд тусгасан үзүүлэлтүүдээр бүрэн шинжилгээ хийж гүйцэтгэл 100 хувьтай хангагдлаа. Агаарын чанар: 2 үзүүлэлтээр шинжилгээ хийж, дүнг БОХЗТЛ-ийн ахлах инженерт хүргүүлсэн. Усны чанар: 5–12 үзүүлэлтээр шинжилж, хяналтын дүнг тогтмол шинэчилж ажиллав. Хөрсний чанар: 3 үзүүлэлтээр шинжилгээ хийж, холбогдох дүгнэлт боловсруулсан. <b>Хяналтын нэмэлт шинжилгээ:</b> ХАБҮЛЛ-ээс ирүүлсэн ундны усанд нитрит тодорхойлох хяналтын дээжийг 10 дугаар сарын 30-нд шинжилж, “Хангалттай” үнэлгээ өгсөн.</p>	99,6

1	2	3	4	5	6	7	8
						<p><b>Гадаргын усны чанарын шинжилгээ:</b>Эг-Хантай, Орхон-Сайхан, Эрэн-Тэшиг, Харгал-Тэшиг, Зүүнтүрүү-Булган, Сэлэнгэ-Хялганат болон бусад харуулуудаас нийт 31 дээж авч, 18 үзүүлэлтээр MNS 4586:2024 стандартаар химийн найрлагыг тодорхойлов.</p> <p><b>Шинжилгээгээр:</b>Зүүнтүрүү, Эг, Сэлэнгэ голд кальцийн агууламж 1.7-2.6 дахин, Аммонийн агууламж 1.1-5.0 дахин, Эгийн голын фосфорын агууламж 1.6 дахин стандарт хэмжээнээс давсан бохирдолтой байгааг тогтоов. Бусад үзүүлэлтүүд стандартын шаардлага хангаж, давж гарсан бохирдол илрээгүй.</p> <p><b>Хаягдал усны шинжилгээ:</b> “Булган Мээж” ХХК-ийн ТЦ байгууламжийн орох, гарах хэсгээс 22 дээж авч, 10 үзүүлэлтээр MNS 4943:2015 стандартаар шинжилгээ хийв. Дүнгээр: Нийт азотын агууламж 2.2-12.5 дахин, Фосфорын агууламж 1.6–5.8 дахин, ПИЧ 1.3–2.8 дахин их, Цэвэршилтийн түвшин 31.2-50.6% байгааг тогтоолоо. Шинжилгээний дүн усны чанарын хяналт шинжилгээ 99,40%, агаарын шинжилгээний дүн 98,8%, хөрсний хяналт шинжилгээ 100%-тай, нэгдсэн дүнгээр 99,46%-тайгаар дүгнүүлэн ажилла.</p>	
2.8	Аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Жилийн ажлын ерөнхий дүн. хувиар	2024 онд <b>100% дүгнэгдсэн</b>	<b>100% хадгалана</b>	4-р сарын 24-ний байдлаар Булган аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөх хэрэгцээ шаардлага байгаа талаар үнэлгээ хийхэд 7.5 буюу /их/ ЦАЗН-х хэрэгцээ шаардлагатай байгааг харуулсан. Иймд Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын А/26 тушаал, УЦУОШТ-ийн даргын Б/09 дугаар тушаалуудын дагуу ЦАЗН-х үйл ажиллагааг 4 дүгээр сарын 25-наас 8 дугаар сарын 10-ныг хүртэл аймгийн хэмжээнд нийт 8 удаа ЦАЗН-х үйл	1 0 0

1	2	3	4	5	6	7	8
						ажиллагааг зохион байгууллаа. Үүнээс 6 үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж хуурайшлын зэргийн бууруулж, хөрсний чийгийг нэмэгдүүлснээр, газар тариалан болон бэлчээрийн ургамал ургах таатай нөхцөлийг бүрдүүлээд байна. 2 үйл ажиллагаа нь үүлэнд нөлөөлөх нөхцөл бүрдээгүй.	
2.9	Архив, мэдээллийн дэд сангийн хөтөлбөрт ажлыг бүх салбар нэгжийн хэмжээнд бүрэн гүйцэтгэж ажилласан байх, мэдээллээр үйлчлэх	Улсын төсөв	- Архивын болон мэдээллийн сангийн ажлын нэгдсэн дүн, хувь,	2024 онд -Архивын хөтөлбөрт ажил-99.71% -Мэдээллийн сангийн хөтөлбөрт ажил -99.96% -Шинжилгээний ажлын нэгдсэн дүн- <b>99.83% дүгнэгдсэн</b>	-Архивын хөтөлбөрт ажил-100% - Мэдээллийн сангийн хөтөлбөрт ажил -100% хүргэх Шинжилгээний ажлын нэгдсэн дүн- <b>100% хүргэнэ</b>	2024.XII сарын 403файл, 35,09мв, 2025.I-X сарын 5397файл, 907mb мэдээ хүлээн авч шалган, тасалдлын протокол хөтлөж, актаар баталгаажуулан АМНС-д сүлжээгээр хүргэсэн. Дашинчилэн харуулын автомат станц ажиллаж байгаа ч мэдээллийг архивлах боломжгүй байгаа. Могод өртөөний LOG-3 архивлах боломжгүй байгаа. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 100%-тай байна.	80
2.10	Цаг агаарын урьдчилсан мэдээг цаг хугацаанд нь чанартай гаргаж үйлчлэх	Улсын төсөв	НМ+ХМ+5ХМ= дундаж таарц, %	НМ 96.3%, 1ХМ 94.3%, 5ХМ 90.4% дундаж таарц= <b>93.7% дүгнэгдсэн</b>	НМ 96.4%, 1ХМ 94.4%, 5ХМ 90.5% дундаж таарц= <b>93.8% хүргэнэ</b>	-Нарийвчилсан урьдчилсан мэдээний таарц-96.0%, 1 хоногийн урьдчилсан мэдээний таарц-94.5%, 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц-91.1%-тай тус тус зохиож дундаж таарц 93.9% байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1%-иар ахиулж ажиллаа. -Холбогдсон иргэд, ААН-д хүссэн цаг агаарын мэдээ, мэдээллээр зөвлөмж өгч үйлчилж ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8
2.11	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх	Улсын төсөв	АУ, ГҮ-ийн СМ, УСМ-ний Таарц+Онч+Урьдчилан илрүүлэлт=дундаж таарц, %	Таарц 90.0%, онч 92.7%, урьдчилан илрүүлэлт 100%, дундаж таарц= <b>94.2% дүгнэгдсэн</b>	Таарц 90.1%, онч 92.8%, урьдчилан илрүүлэлт 100%, дундаж таарц= <b>94.3% хүргэнэ</b>	Сэрэмжлүүлэг мэдээний таарц 100%, онч 100%, илрүүлсэн байдал 100%-тай зохиож дундаж таарц 100%-тай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7%-иар ахиулж цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх үүргээ цаг тухайд нь биелүүлж ажиллаа.	100
2.12	Нислэгийг мэдээгээр үйлчилж нислэгийн аюулгүй байдлыг хангасан байх	Улсын төсөв	Шуурхай үйлчилгээ, зохицуулалт, мэдээ зохиолтын чанар, УМ-ний таарц =дундаж дүн, %	Шуурхай үйлчилгээ 100%, Шуурхай зохицуулалт 100%, мэдээ зохиолтын чанар 92.8%, УМ-ний таарц 96.1%-дундаж дүн= <b>97.2% дүгнэгдсэн</b>	Шуурхай үйлчилгээ 100%, Шуурхай зохицуулалт 100%, мэдээ зохиолтын чанар 96.0%, УМ-ний таарц 96.2%-дундаж дүн= <b>98.0% хүргэнэ</b>	Шуурхай үйлчилгээ 100%, шуурхай зохицуулалт 100%, мэдээ зохиолтын чанар 96.0%, УМ-ний таарц 96.7%=дундаж дүн 98.1%+1.5=99.6 байна. Өмнөх онтой харьцуулахад Нислэгийг цаг агаарын мэдээ, мэдээллээр ханган үйлчлэх ажлын чанар 1.6%-иар өссөн байна.	100
2.13	Байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн судалгаа, бүртгэл хийх	Улсын төсөв	Байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн бүртгэгдсэн тоо, хохирлын хэмжээ	2024 онд Булган аймгийн нутгаар аюултай үзэгдэл 59 удаа, гамшигт үзэгдэл 9 удаа ажиглагдаж нийт 1140871 мал хорогдсон, 159 айлын хашаа, гэр нурсан, 3 гүүр эвдэрсэн, 2 машин урссан, 7 цахилгааны шон унасан мөн	<b>Хөтөлбөрт ажил 100% байна.</b>	2025 онд/2024 оны 12-р сараас 2025 оны 11-р сар/ Булган аймгийн нутгаар нийт 79 удаагийн аюултай үзэгдэл, 4 удаа гамшигт үзэгдэл болсон. Нөөлөг салхи, хүчтэй салхи, шороон шуурга, орон шуурга, мөндөр, их цасны аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдаж хохирол учраагүй байна.	100

1	2	3	4	5	6	7	8
				аянга бууц айл болон албан байгууллагын тоног төхөөрөмж шатсан зэрэг хохирол учирсан байна.			
2.14	Байгууллагын архив, мэдээллийн дэд санд баяжилт хийх	Улсын төсөв	Хадгаламжийн нэгжийн тоо Гүйцэтгэлийн хувиар	100%	100%	<p>1.Цаг уур, уур амьсгалын шинжилгээний мэдээ барим-тын хөмрөгт 49ХН-10164 хуудас</p> <p>2.ХААЦУ-н шинжилгээний мэдээ баримтын хөмрөгт: 38ХН- 1676 хуудас</p> <p>3.Ус судлалын шинжилгээний баримтын хөмрөгт 23ХН-5784хуудас</p> <p>4.Байгаль орчны хяналт шинжилгээний баримтын хөм-рөгт 4ХН-60 хуудас</p> <p>5.Цаг агаарын зураг мэдээний хөмрөгт 2ХН-1799 хуудас</p> <p>Нийт 116ХН-19483 хуудас цаасан баримт хүлээн авч данс бүртгэл хөтлөв.</p> <p>1. Булган, Гурванбулаг, Хутаг, Могод,Тэшиг өртөөдийн температурын өөрөө бичигчийн 1585ш лент,</p> <p>2.Булган, Хутаг, Могод, Тэшиг өртөөдийн чийгийн өөрөө бичигчийн 1311 лент</p> <p>3. Зургаан өртөөний даралтын өөрөө бичигчийн 317ш</p> <p>буюу нийт 3213 ш лент тус тус актаар хүлээн авч, данс бүртгэл хөтлөн, бүртгэлийг баталгаажулан II/14-нд АМНС-д Багажгүй шалтгааны улмаас Ингэттолгой,Гурванбулаг, тэшиг,</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>могод өртөөний чийг, температур, даралтын өөрөө бичигч жилийн болон сар өдрөөр ажиллаагүйгээс 1497ш лент архивт дутуу орж хүргэсэн.</p> <p>5 хөмрөгийн 2024 оны баримтыг салбар бүрээр бүртгэн дүнг гарган нэгтгэсэн ба архив дахь цаасан баримт 4862 ХН-725490 хуудас болж АDRSS-н сан дахь барим-ын тоотой тулсан. Мэдээг xls файлаар V/06-нд АМНС-д хүргэж гүйцэтгэл 100%-тай байна.</p>	
<p><b>ГУРАВ. ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b></p> <p>Төсвийн тухай хууль</p> <p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам 2.1.3.1</p> <p>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 16.1, 37.1.2, 38.1.9, 51.1.2, 51.1.4 заалт, Шилэн дансы тухай хуулийн 4, 6 дугаар зүйл</p> <p>Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар заалт</p>							
3.1	Төрийн албан хаагчийн бүртгэл, тайланг csc.gov.mn цахим хуудсанд хүний нөөцийн системээр гаргах	Улсын төсвөөр	-Мэдээлэл хугацаанд шинэчилсэн байдал (хувиар)	2024 онд -Сар бүр байгууллагын нийт 86 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулж шинэчилсэн. <b>Гүйцэтгэл 100%</b>	-Сар бүр байгууллагын нийт 87 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулж шинэчилсэн байна. <b>Гүйцэтгэл 100%</b>	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын дагуу хувийн хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон байгууллагын албан бичиг хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөн ажиллав. Байгууллагын болон албан хаагчийн хувийн мэдээллийн нууцыг чанд хадгалж, ажилтнуудын хувийн хэргийг тусгай сейфэнд хадгалан хамгаалалтыг ханган ажиллаж байна. Мөн ажилд шинээр орсон, ажлаас гарсан болон албан тушаалын	1 0 0

1	2	3	4	5	6	7	8
						өөрчлөлт орсон албан хаагчдын мэдээллийг ХНУМТ цахим системд бүрэн оруулж, тогтмол шинэчлэн ажиллаж байна.	
3.2	Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу Албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоож мөрдөх, төрд ажилласан жилийн нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэл, унаа хоолны мөнгө, мэргэжлийн зэрэг, ур чадварын нэмэгдлийг батлагдсан төсөвт багтааж тогтооцон олгож мөрдөх	Улсын төсөв	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан хувь	-Хууль эрх зүйн хүрээнд нийт 86 албан хаагч нарт цалин, нэмэгдэл, урамшуулалыг тооцож олгож ажилласан. <b>Гүйцэтгэл 100%</b>	<b>Гүйцэтгэл 100%</b>	Засгийн газрын тогтоолын дагуу 2025 оны 1 дүгээр сард албан хаагчдын цалин 6 хувь нэмэгдсэн ба бусад нэмэгдлийг журмын дагуу бүрэн олгож байна.	1 0 0
3.3	Санхүүгийн мэдээ, тайланг үнэн зөв хийж НББОУС дагуу хугацаанд нь үнэн зөв, гаргаж аймгийн санхүү төрийн сан, Цаг уур орчны шинжилгээний газар хүргүүлсэн байх	Улсын төсвөөр	-Тайланг мэдээний тоо - Төсвийн зарцуулалтын хувь	-2024 оны жилийн эцсийн тайланг гаргаж Цаг уур орчны шинжилгээний газарт нэгтгүүлсэн, Сангийн яамны Э-тайлангийн нэгтгэлд шивсэн. <b>Хэрэгжилтийг 100 % хангасан.</b>	<b>Хэрэгжилтийг 100 % хангасан байна.</b>	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж 2025 оны 2 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд биечлэн очиж цаг уур орчны шинжилгээний газарт хүргэж өгсөн. Энэ оны 2, 3 дугаар улиралын тайланг хугацаанд гаргаж Э-тайланд шивж баталгаажуулсан.	1 0 0
3.4	Бараа материал болон эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж эд хариуцагчид тавих хяналтыг сайжруулах	Улсын төсвөөр	-Тооллого явуулсан тоогоор, 2 удаа -Бүртгэл судалгаа хийсэн байх (Хувь)	Бараа материал эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд нь хийсэн.	<b>хэрэгжилтийг 100% хангасан байна.</b>	Бараа материал болон эд хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж эд хариуцагчид тавих хяналтыг сайжруулж байна. Байгууллагын даргын 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/16 тоот тушаалаар тооллогын комиссыг томилон	1 0 0

1	2	3	4	5	6	7	8
				<b>Хэрэгжилт 100%</b>		тооллогын ажлыг 6 дугаар сарын 9-13-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан.Жилийн эцсийн тооллогыг зохион байгуулахаар бэлтгэж байна.	
3.5	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, шилэн дансны мэдээ, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж, холбогдох газарт хүргүүлэх	Улсын төсвөөр	-Тайлан мэдээний тоогоор -хэрэгжилт (хувиар)	Төсвийн <b>хэрэгжилт 100% хангасан</b>	Төсвийн гүйцэтгэлийн мэдээний <b>хэрэгжилтийг 100% хангасан байна.</b>	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, шилэн дансны мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан. 11 сарын байдлаар нийт 155 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй байна.	100
3.6	Дараа оны төсвийн төслийг хийж хуулийн хугацаанд хүргүүлсэн байх	Улсын төсөв	- Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан хувь (хувиар)	Дараа оны төсвийн төслийг хуулийн хугацаанд нь гаргаж <b>Хэрэгжилтийг 100% хангасан</b>	Дараа оны төсвийн төслийг хуулийн хугацаанд нь гаргасан байна. <b>Хэрэгжилт 100% байна</b>	2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуваарийн дагуу хийж хугацаанд нь дээд газарт хүргүүлж ажилласан.	100
3.7	Төсвийн удирдлага, санхүү, нягтлан бодох бүртгэл, болон гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, төсвийг үр ашигтай зөв зарцуулж өр авлага үүсгэхгүй ажиллах	Улсын төсөв	Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан хувь	Тухайн оны төсвийг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж өр авлага үүсгэхгүй ажиллах 100% хангасан	Төсвийн жилдээ багтаан өр авлага үүсгэхгүй ажиллана.	Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж энэ оны эхний хагас жилд өр авлага үүсээгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна.	100
3.8	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Улсын төсөв	ХАСХОМ-ийн хугацаа Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан хувь	ХАСХОМ-ийг хугацаанд нь хүргүүлсэн	Холбогдох албан тушаалтнууд ХАСХОМ-ийг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэгт анхаарч ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь 3 албан хаагч явуулсан. Хугацаандаа явсан эсэхд хяналт тавин ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8
3.9	Албан хаагчдын ажиллах нөхцөл, хөдөлмөр, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Улсын төсөв	хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт хувиар	2024 онд төлөвлөгөөний биелэлт 90%	Төлөвлөгөөний биелэлт 90%-иас дээш байна	Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Ажлын байрны тав тух, гэрэлтүүлэг, гаднах орчны өнгө үзэмжийг сайжруулж, ажилтнуудын ажлын ачааллыг бууруулахад чиглэсэн тохижилтын ажлыг хийв. 7 хоног бүр 2 цагийг идэвхтэй хөдөлгөөнөөр өнгөрөөх зорилгоор заал авч идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэнддээ анхаарч байна.	100
